



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/125/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Гроут финанс Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж Утас: 77721628 Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 92
танай _____-ны № _____-т

БАТЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ А.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Батцэнгэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 13 арга санхүүжүүлэхээр 2,530,137.1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 2,665,959.2 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 үндсэн зорилтын хүрээнд 86 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Данс код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	286,292,439.28	143,759,129.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	147,403,548.89	11,581,440.93
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	147,403,548.89	11,581,440.93
31211	Төрийн сангийн харилцах	147,403,548.89	11,581,440.93
35	БАРАА МАТЕРИАЛ	138,888,890.39	132,177,688.16
351	Түүхий эд материал	2,922,000.00	2,922,000.00
35130	Эм боох материал	2,922,000.00	2,922,000.00
354	Хангамжийн материал	135,966,890.39	129,255,688.16
35410	Бичиг хэргийн материал	45,000.00	45,000.00
35420	Аж ахуйн материал	125,570,520.26	118,859,318.03
35470	Бусад хангамжийн материал	10,351,370.13	10,351,370.13
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,583,048,104.98	7,951,683,580.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,583,048,104.98	7,951,683,580.36
392	Биет хөрөнгө	1,530,692,304.98	7,899,327,780.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,585,656,337.09	7,876,151,816.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(449,372,339.36)	(559,321,951.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,300,000.00	258,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(28,079,166.68)	(40,801,388.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	399,964,757.05	371,328,298.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(199,411,594.97)	(192,919,736.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	291,189,556.04	231,755,661.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(140,323,413.77)	(69,395,159.50)
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,895,772.20	29,895,772.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,945,077.91)	(20,145,077.91)
39217	Ном	30,817,475.29	14,479,545.62
393	Биет бус хөрөнгө	52,355,800.00	52,355,800.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,425,000.00)	(1,425,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	52,280,800.00	52,280,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,869,340,544.26	8,095,442,709.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	23,233,831.89
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	23,233,831.89
413	Өглөг	-	23,233,831.89
4136	Бусад өглөг	-	23,233,831.89
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,500,000.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	14,501,001.82
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	-	7,232,830.07
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,869,340,544.26	8,072,208,877.56
51	Засгийн газрын хувь оролцоо	1,869,340,544.26	8,072,208,877.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	864,114,528.62	864,114,528.62
512	Хуримтлагдсан үр дүн	81,523,761.38	6,284,392,094.68
51210	Өмнөх үеийн үр дүн	81,523,761.38	81,523,761.38
51220	Тайлант үеийн үр дүн	-	6,202,868,333.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зерүү	923,702,254.26	923,702,254.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,869,340,544.26	8,095,442,709.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,427,178,054.30	9,089,300,386.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	213,092,254.30	6,562,163,286.40
120	Нийтлэг татварын бус орлого	213,092,254.30	6,562,163,286.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	213,092,254.30	6,562,163,286.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,145,800.00	3,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан – Үндсэн хөрөнгө	184,649,534.30	6,559,163,286.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан – Бараа материал	24,296,920.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,214,085,800.00	2,527,137,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,095,740,600.00	2,383,099,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,095,740,600.00	2,383,099,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	118,345,200.00	144,037,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	118,345,200.00	144,037,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,312,399,541.55	2,868,212,731.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,312,399,541.55	2,868,212,731.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,244,316,285.55	2,750,681,931.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,627,292,971.17	1,978,052,931.89
210101	Үндсэн цалин	916,905,836.37	1,073,559,439.51
210102	Нэмэгдэл	562,599,904.80	736,093,028.80
210104	Урамшуулал	147,787,230.00	168,400,463.58
2102	Ажил олгогч төлөх нийгмийн даатгал	203,262,936.53	244,476,450.00
210201	Тэтгэврийн даатгал	135,230,336.53	166,243,850.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,008,200.00	19,558,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,504,100.00	9,779,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,504,100.00	9,779,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,016,200.00	39,116,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	113,345,200.00	140,037,900.00
210301	Гэрэл, цахилгаан	25,630,526.00	36,958,633.00
210302	Түлш, халаалт	83,796,850.00	94,717,900.00
210303	Цэвэр, бохир ус	3,917,824.00	8,361,367.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,339,940.00	-
210401	Бичиг хэрэг	1,339,940.00	-
2105	Нормативт зардал	70,318,336.00	90,255,828.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,850.00	-
210502	Хоол, хүнс	70,017,486.00	90,255,828.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,079,450.00	4,266,800.00
210604	Урсгал засвар	7,079,450.00	4,266,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	19,108,148.26	24,013,899.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,145,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,962,348.26	24,013,899.96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	202,569,303.59	269,578,121.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,117,964.00	52,457,772.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,492,860.00	9,367,560.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	144,958,479.59	207,752,788.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,083,256.00	117,530,800.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	68,083,256.00	117,530,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,170,456.00	92,776,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,912,800.00	24,754,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	114,778,512.75	6,221,087,655.37
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	18,219,322.07
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	18,219,322.07
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(18,219,322.07)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	114,778,512.75	6,202,868,333.30

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,218,231,600.00	2,530,137,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,145,800.00	3,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,145,800.00	3,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,145,800.00	3,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	3,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,145,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,214,085,800.00	2,527,137,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,095,740,600.00	2,383,099,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,095,740,600.00	2,383,099,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	118,345,200.00	144,037,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	118,345,200.00	144,037,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,187,954,965.96	2,665,959,207.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,187,954,965.96	2,630,514,907.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,110,405,895.96	2,512,984,107.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,627,292,971.17	1,955,810,900.00
210101	Үндсэн цалин	916,905,836.37	1,051,317,407.62
210102	Нэмэгдэл	562,599,904.80	736,093,028.80
210104	Урамшуулал	147,787,230.00	168,400,463.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	203,262,936.53	244,476,450.00
210201	Тэтгэврийн даатгал	135,230,336.53	166,243,850.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,008,200.00	19,558,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,504,100.00	9,779,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,504,100.00	9,779,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,016,200.00	39,116,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,345,200.00	140,037,900.00
210301	Гэрэл, цахилгаан	25,630,526.00	36,958,633.00
210302	Түлш, халаалт	83,796,850.00	94,717,900.00
210303	Цэвэр, бохир ус	3,917,824.00	8,361,367.00
2105	Нормативт зардал	66,446,370.00	90,255,828.00
210502	Хоол, хүнс	66,446,370.00	90,255,828.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	7,000,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	7,000,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,108,148.26	24,213,899.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,145,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,962,348.26	24,213,899.96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,950,270.00	51,189,130.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,422,570.00	40,812,430.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,527,700.00	10,376,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,549,070.00	117,530,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,549,070.00	117,530,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	69,636,270.00	92,776,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,912,800.00	24,754,300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,276,634.04	(100,377,807.96)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	39,398,900.00	35,444,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,398,900.00	35,444,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	39,398,900.00	35,444,300.00
223001	Бусад хөрөнгө	39,398,900.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	35,444,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(39,398,900.00)	(35,444,300.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(9,122,265.96)	(135,822,107.96)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	156,525,814.85	147,403,548.89
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	147,403,548.89	11,581,440.93

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	864,114,528.62	923,702,254.26	81,523,761.38	1,869,340,544.26
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	864,114,528.62	923,702,254.26	(33,254,751.37)	1,754,562,031.51
Тайлант үеийн үр дүн	-	-	114,778,512.75	114,778,512.75
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	864,114,528.62	923,702,254.26	81,523,761.38	1,869,340,544.26
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	864,114,528.62	923,702,254.26	81,523,761.38	1,869,340,544.26
Тайлант үеийн үр дүн	-	-	6,202,868,333.30	6,202,868,333.30
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	864,114,528.62	923,702,254.26	6,284,392,094.68	8,072,208,877.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,714,348,348.89	2,665,959,207.96	48,389,140.93	98.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,714,348,348.89	2,665,959,207.96	48,389,140.93	98.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,591,878,048.89	2,548,428,407.96	43,449,640.93	98.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,985,212,348.89	1,955,810,900.00	29,401,400.00	98.52
210101	Үндсэн цалин	1,134,033,800.00	1,051,317,407.62	82,716,392.38	92.71
210102	Нэмэгдэл	748,198,548.89	736,093,028.80	12,105,471.20	98.38
210104	Урамшуулал	102,980,000.00	168,400,463.58	(65,420,463.58)	163.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	248,151,700.00	244,476,450.00	3,675,250.00	98.52
210201	Тэтгэврийн даатгал	168,743,100.00	166,243,850.00	2,499,250.00	98.52
210202	Тэтгэмжийн даатгал	19,852,200.00	19,558,400.00	293,800.00	98.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,926,100.00	9,779,000.00	147,100.00	98.52
210204	Ажилгүйдлийн даатгал	9,926,100.00	9,779,000.00	147,100.00	98.52
210205	Эрүүлмэндийн даатгал	39,704,200.00	39,116,200.00	588,000.00	98.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,037,900.00	140,037,900.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	43,644,900.00	36,958,633.00	6,686,267.00	84.68
210302	Түлш, халаалт	87,673,000.00	94,717,900.00	(7,044,900.00)	108.04
210303	Цэвэр, бохир ус	8,720,000.00	8,361,367.00	358,633.00	95.89
2105	Нормативт зардал	95,945,100.00	90,255,828.00	5,689,272.00	94.07
210502	Хоол, хүнс	95,945,100.00	90,255,828.00	5,689,272.00	94.07
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,000,000.00	7,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	7,000,000.00	7,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,070,100.00	28,213,499.96	856,600.04	97.05
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,070,100.00	28,213,499.96	856,600.04	97.05
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,460,900.00	82,633,830.00	868,770.00	95.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,977,500.00	72,257,130.00	762,070.00	95.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,483,400.00	10,376,700.00	106,700.00	98.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	122,470,100.00	117,530,800.00	1,023,700.00	95.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	122,470,300.00	117,530,800.00	1,023,700.00	95.97
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	97,715,800.00	92,776,500.00	1,023,700.00	94.95
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,754,500.00	24,754,300.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,714,348,348.89	2,530,137,100.00	184,211,248.89	93.21
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,412,906,900.00	2,383,099,200.00	36,807,500.00	98.48
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,419,906,900.00	2,383,099,200.00	36,807,500.00	98.48
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	147,037,900.00	144,037,900.00	3,000,000.00	97.96
132001	Орон нутгийн төсвөөс	147,037,900.00	144,037,900.00	3,000,000.00	97.96

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	147,403,500.00	3,000,000.00	144,403,500.00	2.04
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,000,000.00	(3,000,000.00)	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	147,403,548.89	-	147,403,500.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	147,403,548.89	147,403,548.89	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	147,403,548.89	11,581,440.93	135,822,107.96	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	64	64	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	41	41	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	14	14	-	100.00
620004	Гэрээт ажилтан	8	8	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	513	513	-	100.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	513	513	-	100.00
630001	Төрийн өмчит ЕБС	513	513	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	64	64	-	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	35	35	-	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1	1	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	28	28	-	100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй нийт 16,149.6 мянган төгрөгийн зөрчил² илэрч 8,605.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 7,544.6 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 16,149.6 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 29,213.8 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. "Балансын урамшуулал олгох тухай" тус сургуулийн захирлын 2025.09.25-ны өдрийн А/36 дугаар тушаалыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөг, няравт 1,105.0 мянган төгрөг, нийт "балансын урамшуулал" 2,664.0 мянган төгрөгийг "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.1.2 Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалд 24,754.3 мянган төгрөгийг 64 ажилтанд олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь болох 2,475.4 мянган төгрөгийг суутгасан байх бөгөөд 5,941.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган авч, төсөвт төлөөгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна": 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.2 Зөвлөмж

3.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хувь хүнд олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын мэдээ ХМ_11(2) маягт болон Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан ТТ-11 маягтаар татварт 5,069.2 мянган төгрөгийг тайлагнаагүй байна.

Энэ нь "Хувь хүний орлогын албан татварын хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-д "Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ." заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэх.

3.2.2. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгохдоо Хувь хүний орлогын албан татвар 10%-ийг суутгаж татварын байгууллагад төлсөн 2,475.4 мянган төгрөгийг татварын тайланд оруулж тайлагнаагүй байна.

Энэ нь "Хувь хүний орлогын албан татварын хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-д "Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ." заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөгжлийн бэрхшээлтэй хувь хүнд олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын мэдээ ХМ_11(2)-г тайлагнаагүй	1	5,069.2	-	-	-	-	1	5,069.2
Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгохдоо суутгаж төлсөн Хувь хүний орлогын албан татварын 10%-ийг татварын тайланд оруулаагүй	1	2,475.4	-	-	-	-	1	2,475.4
Балансын урамшуулал олгосон	1	2,664.0	-	-	1	2,664.0	-	-
Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тайлагнаагүй байна.	1	5,941.0	-	-	1	5,941.0	-	-
Дүн	4	16,149.6	-	-	2	8,605.0	2	7,544.6